



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс авсан 2023 оны 6-р сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын арга ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Хүснэгт:1

Асуулт:1			
		Иргэдийн тоо	Хувь
Таны хүйс	Эрэгтэй	89	35.6%
	Эмэгтэй	161	64.4%
Нийт		250	100.0%

График:1




Дүгнэлт: Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 250 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 64.4% эмэгтэй, 35.6% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.



Хүснэгт:2

Асуулт:2			
		Иргэдийн тоо	Хувь
Таны нас	16-21	4	1.6%
	22-30	39	15.6%
	31-40	66	26.4%
	41-50	71	28.4%
	50-ээс дээш	70	28%
Нийт		250	100.0%

График:2



Дүгнэлт: Насны хувьд авч үзвэл 16-21 насны 4 даатгуулагч, 22-30 насны 39 даатгуулагч, 31-40 насны 66 даатгуулагч, 41-50 насны 71 даатгуулагч, 50-иас дээш насны 70 даатгуулагч судалгаанд хамрагдсан байна. Нийгмийн даатгалын байгууллагаар 6-р сард үйлчлүүлсэн даатгуулагчдын ихэнх хувь нь 41-50 насныхан буюу 28.4% байна.



Хүснэгт:3

Асуулт:3		Иргэдийн тоо	Хувь
Та хэдэн тоотын байцаагчаас үйлчилгээ авсан бэ?	1	3	1.2%
	2	0	0.0%
	3	55	22%
	4	53	12.2%
	5	23	9.2%
	6	15	6.0%
	7	0	0.0%
	8	0	0.0%
	9	24	9.6%
	10	27	10.8%
	Угтах үйлчилгээ	50	20%
Нийт		250	100.0%

График:3




Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний хэсэгт нийт 7 байцаагч, угтах үйлчилгээний ажилчид зөвлөгөө мэдээлэл үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хүргэн ажиллалаа.



Хүснэгт:4

Асуулт:4			
	Иргэдийн тоо	Хувь	
Та яг одоо ямар үйлчилгээ авахаар ирсэн бэ?	Тэтгэвэртэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ	75	30.0%
	Тэтгэмжтэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ	58	23.2%
	Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ	41	16.4%
	Сайн дурын даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ	53	21.2%
	Нийгмийн даатгалын тайлантай холбоотой үйлчилгээ	4	1.6%
	Лавлагаа	14	5.6%
	Бусад	5	2.0%
Нийт	250	100.0%	

График:4




Дүгнэлт: Нийт 250 даатгуулагч судалгаанд хамрагдснаас 5-р сард тэтгэврийн даатгалтай холбоотой үйлчилгээ авахаар 78 даатгуулагч (31.2%) бол 6-р сард тэтгэврийн даатгалтай холбоотой үйлчилгээ авахаар 75 даатгуулагч (30.0%) болж буурсан үзүүлэлттэй харагдаж байна. 5-р сард тайлантай холбоотой үйлчилгээ авахаар 4 даатгуулагч (1.6%), 6-р сард 4 даатгуулагч (1.6%) буюу хэвийн үзүүлэлттэй харагдаж байна.



Хүснэгт:5

Асуулт:5			
		Иргэдийн тоо	Хувь
Та үйлчилгээ авахын тулд хэдэн минут хүлээсэн бэ?	Шууд үйлчлүүлсэн	173	69.2%
	5-15 минут	68	27.2%
	15-30 минут	7	2.8%
	30 минутаас 1 цаг	2	0.8%
	1-2 цаг	0	0.0%
Нийт		250	100.0%

График:5



Дүгнэлт: Хүлээлгийн хугацааны хувьд 5-р сард даатгуулагчдын 77.6% буюу 194 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээ авахын тулд шууд үйлчлүүлсэн бол 6-р сард 69.2% буюу 173 даатгуулагч шууд үйлчлүүлсэн байна. Өмнөх сартай харьцуулахад шууд үйлчилгээ авсан даатгуулагчдын тоо буурсан үзүүлэлттэй харагдаж байна.



Хүснэгт:6

Асуулт:6		
	Иргэдийн тоо	Хувь
Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу?	Бүрэн өгч чадсан	245 98.0%
	Хангалтгүй	3 1.2%
	Бүрэн өгч чадаагүй	2 0.8%
	Муу	0 0.0%
Нийт	250	100.0%

График:




Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуулгын хувьд нийт судалгаанд оролцогчдын 98.0% буюу 245 даатгуулагч “Бүрэн өгч чадсан” гэсэн хариулт өгсөн бол 1.2% буюу 3 даатгуулагч бүрэн өгч чадаагүй гэж хариулсан. Харин 0.8% буюу 2 даатгуулагч “Хангалтгүй” байна гэсэн үнэлгээ өгсөн. 5-р сард “Бүрэн өгч чадсан” гэсэн хариултыг өгсөн даатгуулагчдын үзүүлэлт 0.8% буурсан байна.



Хүснэгт:7

Асуулт:7			
		Иргэдийн тоо	Хувь
Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ?	Маш сайн	179	71.6%
	Сайн	66	26.4%
	Дунд	4	1.6%
	Муу	1	0.4%
Нийт		250	100.0%

График:7




Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд 71.6% буюу 179 даатгуулагч байцаагчийн мэргэжлийн ур чадварыг “Маш сайн” гэж үнэлсэн бол 26.4% буюу 66 даатгуулагч “Сайн” гэж үнэлсэн байна. Бусад даатгуулагчдын хувьд 1.6% буюу 4 даатгуулагч “Дунд” гэж үнэлсэн бол муу гэж 1 даатгуулагч үнэлсэн байна.



Хүснэгт:8

		Асуулт:8	
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харьцаа, хандлагыг хэрхэн үнэлж байна вэ?	Маш өндөр ханамжтай	167	66.8%
	Сэтгэл ханамжтай	79	31.6%
	Сэтгэл ханамжгүй	4	1.6%
Нийт		250	100.0%

График:8



Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын хувьд хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултын хувьд 66.8% буюу нийт 167 даатгуулагч “Маш өндөр ханамжтай” бол 31.6% буюу 79 даатгуулагч “Сэтгэл ханамжтай” гэсэн хариулт өгсөн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харилцаа, хандлагад 1.6% буюу 4 даатгуулагч сэтгэл ханамжгүй гэж үнэлсэн байна.



Хүснэгт:9

Асуулт:9			
		Иргэдийн тоо	Хувь
Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ?	Маш сайн	184	73.6%
	Сайн	58	23.2%
	Дунд	7	2.8%
	Муу	1	0.4%
Нийт		250	100.0%

График:9




Дүгнэлт: Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд 5-р сард 72.0% 180 даатгуулагч маш сайн гэж хариулсан бол 6-р сард 73.6% буюу 184 даатгуулагч сэтгэл ханамж “Маш сайн” гэж хариулсан нь өмнөх сараас 1.6% өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Харин 23.2% буюу 58 даатгуулагч сэтгэл ханамж “Сайн” гэсэн хариулт өгсөн байна. Бусад даатгуулагчийн хувьд 2.8% буюу 7 даатгуулагч дунд, 0.4% буюу даатгуулагч байцаагчийн үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамж “Муу” гэсэн хариулт өөрчлөгдөөгүй байна.



Хүснэгт:10

Асуулт:10		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ?	Маш сайн	177	70.8%
	Сайн	69	27.6%
	Дунд	2	0.8%
	Муу	1	0.4%
Нийт		250	100.0%

График:10



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ? асуулгыг авч үзвэл даатгуулагчдын 70.4% буюу 176 даатгуулагч “Маш сайн”, 29.2% буюу 73 даатгуулагч “Сайн”, 0.4% буюу 1 даатгуулагч “Дунд” үнэлгээ өгсөн байна.



Хүснэгт:11

Асуулт:11		Иргэдийн тоо	Хувь
Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ?	1 удаа	189	75.6%
	2 удаа	48	19.2%
	3-4 удаа	8	3.2%
	5-с дээш удаа	2	0.8%
	Маш олон удаа	3	1.2%
Нийт		250	100.0%

График:11



Дүгнэлт: Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ? гэсэн асуултад нийт 250 даатгуулагч хамрагдснаас 5-р сард 188 даатгуулагч 1 удаа ирэх шаардлага гарсан гэсэн бол 6-р сард 189 даатгуулагч болж өссөн байна. Харин 5-р сард 1 удаа үйлчилгээ авахын тулд 3-4 удаа ирэх шаардлага гарсан 10 даатгуулагч байсан бол 6-р сард 8 даатгуулагч болж буурсан байна. Иймд даатгалын үйлчилгээ авахаар ирсэн даатгуулагчдыг олон дахин явуулах асуудал буурч байгааг харуулж байна.



Хүснэгт: 12

Асуулт: 12			
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү?	Маш сайн	109	26.0%
	Сайн	123	39.6%
	Дунд	16	33.6%
	Муу	2	0.8%
Нийт		250	100.0%

График:12



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү? Гэсэн асуулгын хувьд үйлчилгээний ил тод нээлттэй байдлын хувьд даатгуулагчдын 43.6% буюу 109 даатгуулагч “Маш сайн”, 49.2% буюу 123 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдалд “Сайн”, 6.4% буюу 16 даатгуулагч үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлэхдээ “Дунд”, 0.8% буюу 2 даатгуулагч муу гэж хариулсан байна.



Хүснэгт:13

Асуулт:13			
		Иргэдийн тоо	Хувь
Ажилтнуудын буруутай үйлдлээс болж таньд ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу?	Тийм	12	4.8%
	Үгүй	238	95.2%
Нийт		250	100.0%

График:13



Дүгнэлт: Даатгуулагчдад ямар нэгэн хүндрэл чирэгдэл учруулж, хүнд суртал гаргаж байсан эсэх асуултанд нийт даатгуулагчийн 95.2% буюу 238 даатгуулагч “үгүй” гэсэн хариулт өгсөн. Үүнээс 4.8% буюу 12 даатгуулагч дээрх асуултанд “тийм” гэсэн хариулт өгсөн байна. өмнөх сарын үзүүлэлтээс ажилтны буруутай үйлдлээс болж таньд ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу гэсэн асуултын хувьд тийм гэсэн хариулт 1.6 хувиар өссөн байна.



Хүснэгт:14

Асуулт:14		
	Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод орчин нөхцөл, тав тухыг хэрхэн үнэлж байна вэ?	Маш сайн	121 48.4%
	Сайн	89 35.6%
	Боломжийн	34 13.6%
	Муу	6 2.4%
Нийт	250	100.0%

График:14



Дүгнэлт: Тав тух, орчин нөхцөлийн хувьд иргэд даатгуулагчдын эерэг сэтгэгдэлтэй буюу хэлтсийн зохион байгуулалт дотоод орчин нөхцөлийг 5-р сард 30.8% буюу 77 “Маш сайн” бол 6-р сард 48.4% буюу 121 даатгуулагч маш сайн гэж үнэлсэн нь өмнөх сарын үзүүлэлтээс 17.6% өссөн байна. Харин 5-р сард 80 даатгуулагч буюу 37.2% боломжийн гэж хариулсан бол 6-р сард 34 даатгуулагч буюу 13.6% боломжийн гэж хариулсан байна. Иргэдэд тав тухтай байлгах, орчин нөхцлийг сайжруулах тал дээр 6-р сард үнэлгээ өссөн үзүүлэлттэй гэж харагдаж байна.




Асуулт 15. Танд нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах ямар нэгэн санал, хүсэлт байвал чөлөөтэй бичнэ үү?

1. Сэтгэл ханамж өндөр.
2. Лавлах утас авахгүй юм.
3. Маш сайн байсан.
4. Түргэн шуурхай үйлчилсэнд баярлалаа.
5. Мундаг байсан. /Онц, Онц, Онц/
6. Сайн
7. Баярлалаа.
8. Амжилт.
9. Баярлалаа.
10. Тэтгэвэрт орох гэсэн боловч материалаа бүрдүүлж чадахгүй байгаа учир туслаж өгнө үү!
11. Танай хамт олонд баярлалаа. Сайхан үйлчилгээ эелдэг хамт олон байна.
- 12.4 номер дээр ажиллаж байгаа байцаагч маш сайн хангалттай тайлбарлаж өгсөн. Мөн угтах үйлчилгээний ажилтанд баярлалаа.
13. Баярлалаа
14. Сэтгэл ханамж сайн. Чирэгдэлгүй сайхан үйлчилгээ авсан. Та бүхэнд ажлын амжилт хүсье.
15. Ажиллаж байсан “ТУРУУН” ХХК буруутай.
16. Ажилтнуудын харилцаа хандлага хэвийн сайн юм. Та бүхэнд ажлын амжилт хүсье.
17. Архиваас тань миний бүх материал алга болсон. Одоо 5, 6-н жил болж байна. Энэ удаагийн нэмэгдэлд тэр нөлөөлөх вий гэж зовох юм.
18. Маш их баярлалаа.
19. Тэтгэврийн материалыг лавлах байцаагч тусгай байвал зүгээр байна. Дараа ир, хүнгүй үед ир гээд явуулах юм.
20. Сайн байсан.
21. Сэтгэл ханамжтай байлаа. Танай хамт олонд ажлын амжилт хүсье. Баярлалаа.
22. Авах үйлчилгээгээ бүрэн гүйцэт авлаа.
23. Улам хялбар болж байгаад баярлалаа.
24. Сэтгэл ханамжтай байлаа.



16. Байцаагчийн буруутай үйлдлээс болж ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:

График:16




Дүгнэлт: Дээрх графикаас харахад 5-р сард ихэнх байцаагч ажилтнуудын буруутай үйлдлээс болж хүндрэл, чирэгдэл учирсан бага байгаа бол 6-р сард энэ үзүүлэлт өөрчлөгдөөгүй харагдаж байна.

17. Байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын үнэлэмжийн хувьд дараах үзүүлэлттэй байна:




График:17



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа 4 номертой байцаагчийн үйлчилгээнд маш сайн гэж 40 даатгуулагч хариулсан бол 18 даатгуулагч сайн, 1 даатгуулагч дунд гэж хариулсан байна.

18. Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:

График:18



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултын хувьд 3 дугаартай байцаагчийн хувьд 54 даатгуулагч хүссэн мэдээллийг бүрэн өгч чадсан бол 1 даатгуулагч хангалтгүй гэж үнэлгээ өгсөн байна.

19. Байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултыг авч үзэхэд:




График:19



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 3 дугаартай байцаагчийн хувьд 44 даатгуулагч маш сайн, 10 даатгуулагч сайн гэж үнэлсэн бол 1 даатгуулагч дунд гэж үнэлсэн байна.

20. Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулт дараах үзүүлэлттэй байна.

График:20




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй даатгуулагчид байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд 4 дугаартай байцаагчаас үйлчилгээ авч байгаа 43 даатгуулагч маш сайн, 7 даатгуулагч сэтгэл ханамж сайн гэж хариулсан байна. Харин 2 даатгуулагч дунд, 1 даатгуулагч муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

Сэтгэл ханамжийн индексийн үнэлгээ:



Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлүүлэхдээ 1-10 гэсэн Лайкерьтын шкал (хэмжүүр) ашигласан болно. Уг индексийн агуулгын хувьд 9.00-10.00 байвал хэрэглэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй онолын түвшиний ойлголт юм. 8.00-8.99 хооронд тохиолдолд сэтгэл ханамжтай ба байгууллагууд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага байдаг. Харин 6.00-8.00 хооронд хэрэглэгчийн сэтгэл ханамж дээгүүр түвшинд байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлсэн мэдээлэл юм. Харин 5.99-өөс доош байгаа бол энэ

Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:




Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад 5-р сард 1 дугаартай байцаагч 9.06 үнэлгээ авсан бол 6-р сард 10 болж өссөн байна. Харин 6 дугаартай байцаагч 5-р сард 9.19 байсан бол 6-р сард 8.5 үнэлгээтэй болж буурсан үзүүлэлттэй байна.

Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:




Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэт өгч чадсан уу?



Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэт өгч чадсан уу? Гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 5-р сард 5, 6, 8, 9, 10 дугаартай байцаагч нар 10.0 үнэлгээтэй байсан бол 5-р сард 1, 5, 6, 9 дугаартай байцаагч нар 10.0 үнэлгээтэй байна.

Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:


Та үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг хэрхэн үнэлэх вэ?



Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 5-р сард 1 дугаартай байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлага 8.56 байсан бол 6-р сард 9.27 болж өссөн үзүүлэлттэй байна. 6-р сард бүх байцаагч нарын үзүүлэлт өссөн харагдаж байна.



Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:




Дүгнэлт: Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 5-р сард 9 дугаартай байцаагчийн хувьд 8.86 байсан бол 6-р сард 9.69 болж өссөн үзүүлэлттэй байна. Харин 6 дугаартай байцаагч 5-р сард 9.48 байсан бол 6-р сард 9.17 үнэлгээтэй болж буурсан үзүүлэлттэй байна.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 5 сарын үйлчилгээ, орчин нөхцлийг үнэлэх судалгааны 10-н асуултыг индекслэхэд **9.03** байна.



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дундаж индекс



Судалгааны нэгтгэл хийсэн: Н.Оюун-Эрдэнэ/...../